



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 12 сарын 12 өдөр

Дугаар А/668

Мөрөн сум

Олон нийтийг хамарсан үйл ажиллагааг
хязгаарлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Боловсролын ерөнхий хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.5, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.7, 28.10, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, 11.1.10 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Эрүүл мэндийн газрын 2024 оны 12 дугаар сарын 12 -ны өдрийн тандалтын дүгнэлтийн дагуу аймгийн хэмжээнд үүссэн томуу болон томуу төст өвчний дэгдэлтийг хязгаарлах, тархалтыг зогсоох, боловсролын байгууллагын суралцагчдын эрүүл мэндийг хамгаалах зорилгоор хичээл сургалтын үйл ажиллагаанаас бусад олон нийтийг хамарсан үйл ажиллагаа явуулахыг 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдрөөс 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдөр хүртэл хориглосугай.

2. Бүх шатны боловсролын байгууллагын суралцагчдад өвчлөлөөс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг, зөвлөмжийг хүргүүлэн мөрдүүлж, хичээл сургалтын үйлчилгээг хэвийн зохион байгуулахыг Боловсролын газар (О.Бадраа)-т даалгасугай.

3. Томуу, томуу төст өвчний мэдээ мэдээлэлд дүгнэлт хийж, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд онцгой анхаарч ажиллахыг Эрүүл мэндийн газар (М.Үүрийнбаяр)-т үүрэг болгосугай.

4. Эрүүл мэндийн төвийн эм эмнэлгийн хэрэгсэл, хүний нөөцийн бэлэн байдлыг ханган шаардлагатай тохиолдолд нэмэлт ор дэлгэх асуудлыг шийдвэрлэж, анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудыг мэргэжил арга зүйгээр хангаж, шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлэж ажиллахыг Эрүүл мэндийн газар (М.Үүрийнбаяр), Нэгдсэн эмнэлгийн захирал (Г.Оюунжаргал), сумын Эрүүл мэндийн төвийн дарга, сумын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

5. Томуу, томуу төст өвчнөөр өвчилсөн 0-5 насны хүүхэдтэй эцэг эхчүүдэд эмнэлгийн магадалгааг үндэслэн 3-5 хоног цахим болон богиносгосон цагаар ажиллах боломж нөхцөлөөр хангахыг Төр, хувийн хэвшил, аж ахуйн нэгж, байгууллагуудын дарга, захирал нарт даалгасугай.

6. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Нийгмийн бодлогын хэлтэс (Д.Цэцэгмаа)-д даалгасугай.

ДАРГА

Л.ТӨМӨРБААТАР



Захирамж2024

6712012035